




2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

ДАМЖУУЛАХ

Сүлжээ



№03 (156) 2023 оны 08 сар

ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН

10

Жилийн ой тохиолоо

Монгол орны гал голомтыг мөнхөд бадрааж, илч гэрлээр тасралтгүй найдвартай дамжуулах үйлсийн гэрч болж нэгэн аравны арвин түүхийг бүтээсэн ЦДҮС ТӨХК-ийн Говийн бүсийн салбар “Хөгжилд хөтөлсөн 10 жил” ойн арга хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдөр зохион байгууллаа. Тус салбарын ойд ЦДҮС ТӨХК-ийн удирдлага, салбар, хэлтсийн дарга нар, Говийн бүсийн салбарын тулгын чулууг тавилцсан ахмадууд, үе үеийн удирдлага, ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл болсон нийт 160 гаруй ажилтан оролцлоо. Ойн арга хэмжээний хүрээнд ирсэн зочдыг угтахар салбарын хашаанд хүндэтгэлийн асар барьж ажилтнуудын өөрсдийн гар доорх материалыг ашиглан угтах булангаа тохижууллаа. Мөн энэ үеэр арван жилийн арвин түүхийн гэрч болсон гэрэл зургийн музей гаргаж ирсэн зочдод танилцуулсан.



“Хөгжилд хөтөлсөн 10 жил” ойн арга хэмжээний баярын хурлыг Дундговь аймгийн Сайнцагаан сумын “Төв халхын дуулалт жүжгийн театр”-т амжилттай зохион байгууллаа. Баярын хурлын нээлтэд хүрэлцэн ирсэн эрхэм зочид дурсамж, дурдатгал, үнэт сургаалиа дэлгэж, чин сэтгэлийн талархал дэвшүүлэн ажлын амжилт хүслээ. Хүндэт зочдыг төлөөлж:

- ЦДҮС ТӨХК-ийн Ерөнхий инженер, Техникийн ухааны доктор Б.Эрхэмзаяа
- ЦДҮС ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын дарга, Техникийн ухааны магистр Н.Бямбадорж
- ЦДҮС ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын анхны дарга, Техникийн ухааны магистр, Монгол Улсын зөвлөх инженер Д.Цэрэндамба
- ЦДҮС ТӨХК-ийн Үйлдвэрчний хорооны дарга Ц.Мөнхбаатар
- Монгол Улсын Аж Үйлдвэрийн гавьяат ажилтан, хугацаагүй эрхэт зөвлөх инженер, ЦДҮС ТӨХК-ийн Ахмадын хорооны дарга Л.Дарамбазар
- Хэлтсийн дарга нар, салбар салбарын төлөөллүүд
- Ахмад үеийг төлөөлж ЦДҮС ТӨХК-ийн Говийн Бүсийн Салбарын ахмад ажилтан Монгол Улсын Зөвлөх инженер Ж.Шарав, ахмад ажилтан Б.Дамбийням
- Салбарын ажилтнуудын дунд үеийн төлөөлөл Салбарын диспетчер инженер Х.Эрхэмсайхан, инженерийн албаны Зураг төсвийн инженер Г.Содномцэрэн
- Салбарын залуу ажилтны төлөөлөл 220/110/35/10 кВ-н Тавантолгой дэд станцын ээлжийн инженер З.Баасанжаргал нар үг хэллээ.



Салбарын ойн арга хэмжээний үеэр “Эрчим хүчний яамны Тэргүүний ажилтан” цол тэмдгээр засварын албаны шугам засварын монтер М.Даваадорж, “Эрчим хүчний салбарын 100 жилийн ой” медалиар ахмад ажилтан Б.Дамбийням, АШҮА-ны ахлах бөгөөд диспетчер инженер Б.Бүрэннэмэх, “Зам тээврийн яамны тэргүүний ажилтан” цол тэмдгээр Тээвэр механизмын хэсгийн суудлын машины жолооч Н.Ганболд, “Дундговь аймгийн Сайнцагаан сумын хүндэт иргэн”-ээр салбарын ерөнхий инженер Д.Цэрэндамба, “Дундговь аймгийн засаг даргын жуух” бичгээр ЗААА-ны дарга Ц.Ганнягт, Тээвэр механизмын хэсгийн



Тусгай зориулалтын машин механизмын жолооч Б.Бат-Эрдэнэ, “Сайнцагаан сумын Засаг даргын жуух” бичгээр Инженерийн албаны засварын инженер Д.Батсуурь, Тавантолгой дэд станцын ээлжийн инженер Т.Бадарчин нар шагнагдсан. ЦДҮС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын нэрэмжит мөнгөн шагналаар Оюутолгой дэд станцын ээлжийн монтер С.Нэмэхбаяр, Мандал дэд станцын ээлжийн техник Ц.Готовдулам, Салбарын даргын нэрэмжит мөнгөн шагналаар ЗААА-ны Хангамжийн мэргэжилтэн Х.Төмөр-Очир, ЗААА-ны үйлчлэгч Д.Лхамноржмаа, ЗААА-ны харуулын ажилтан М.Гантулга, СЭЗА-ны цалин хөлсний нягтлан Л.Мягмарсүрэн, Инженерийн албаны дарга Ц.Эрдэнэчулуун, инженерийн албаны мэдээллийн технологи компьютерийн инженер Х.Эрдэнэсүх, РХАХТА-ны өндөр хүчдэлийн туршилт, хэмжилтийн монтер А.Мягмархүү, РХАХТА-ны РХА-н монтер П.Лувсан-Иш, засварын албаны дэд станцын засварын монтер А.Дорждэрэм, Тээвэр механизмын хэсгийн Суудлын машины жолооч Ц.Бат-Эрдэнэ, АШҮА-ны ээлжийн инженер Ш.Батсайхан, АШҮА-ны ээлжийн инженер Б.Идэр, АШҮА-ны ээлжийн инженер З.Баасанжаргал, АШҮА-ны ээлжийн инженер Х.Мэндбаяр нар тус тус шагнагдсан.

НҮҮР-3

ГЭМТЛИЙГ БҮРЭН УСТГАЖ,
ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИНД
ХОЛБОЛОО

НҮҮР-5

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

НҮҮР-7


ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

НҮҮР-9

ТӨВ УДИРДЛАГА

НҮҮР-11

«ЭРЧИМ ХҮЧНИЙ АЖИЛТНЫ ӨДӨР»-ИЙГ
ТЭМДЭГЛЭВ



ШАГНАЛ ГАРДУУЛАВ



Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын босгон дээр эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн Хархорин А, Б цахилгаан дамжуулах агаарын шугамд 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр гарсан аваарыг богино хугацаанд устгах сэргээн босголтын ажилд мэргэжлийн өндөр ур чадвар гарган идэвх зүтгэлтэй ажилласан тус компанийн ажилтнуудад шагнал гардуулж, баяр дээр баяр нэмлээ. “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн ахлах бөгөөд шугамын засварын инженер С.Ариунбат, Хангайн бүсийн салбарын ерөнхий инженер Б.Анхбаяр, Төвийн бүсийн салбарын засварын албаны ахлах бөгөөд засварын инженер Б.Анхбаяр, “Эрчим хүчний тэргүүний ажилтан” тэмдгээр Улаанбаатар салбарын засварын албаны шугамын засварын монтёр Р.Мөнгөнсаруул, С.Сэргэлэн, дэд станцын засварын монтёр Э.Амарбаясгалан, Төвийн бүсийн салбарын засварын албаны шугамын засварын мастер Б.Саранболд, шугамын засварын монтёр Ш.Бадрах-Алдар, Хангайн бүсийн салбарын сургалт, бүтээмжийн инженер Б.Ундрах, Хархорин хэсгийн нярав Ц.Отгончимэг, Зүүн-Өмнөд бүсийн салбарын засварын албаны дарга Г.Болдхуяг, засварын монтёр А.Төрхишиг, Чойр хэсгийн засварын монтёр М.Чингисбаатар, Говийн бүсийн салбарын засварын албаны шугамын засварын монтёр М.Даваадорж нар тус тус шагнагдаж, энгэрээ мялаав. Шагнал гардуулах ёслолын арга хэмжээ 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Эрчим хүчний яаманд зохион байгуулагдлаа.



ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмаар “Монгол Улсын начин” цол хүртсэн Улаанбаатар салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны нэгдүгээр зэрэглэлийн дэд станцын ээлжийн монтёр Дамдины Тогтохжаргал, байгалийн онц аюултай үзэгдлийн улмаас 110 кВ-ын Хархорин А, Б цахилгаан дамжуулах агаарын шугамд гарсан аваарыг богино хугацаанд устгах сэргээн босголтын ажилд мэргэжлийн өндөр ур чадвар гарган идэвх зүтгэлтэй ажиллаж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 81 дүгээр зарлигаар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнагдсан Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн ахлах бөгөөд шугамын засварын инженер Санжсүрэнгийн Ариунбат нарыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн удирдлага болон хамт олон 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.



АХМАД НАСТАН Х.АДЪЯАД ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 100 ЖИЛИЙН ОЙН МЕДАЛЬ ГАРДУУЛАВ

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Улаанбаатар салбарын ахмад настан Х.Адъяаг компанийн захиргаа, ахмадын хороо хүндэтгэн хүлээн авч Эрчим хүчний салбарын 100 жилийн ойн медаль гардуулж хүндэтгэл үзүүллээ. Х.Адъяа Ардын армийн албанаас эх орны илгээлтээр Аж үйлдвэрийн яамны харьяа Улаанбаатарын цахилгаан шугам сүлжээний газарт 1965 онд ажилчнаар орж, монёрын мэргэжил эзэмшээд эрчим хүчний салбарт 40 гаруй жил ажиллажээ. Ажиллах хугацаандаа тэрбээр, байгууллагын Аварга, V, VI, 5 жилийн гавшгайч, Эрчим хүчний тэргүүний ажилтан цолоор шагнагдаж байсан бөгөөд Монгол Улсын анхны 110 кВ-ын хүчдэлийн Улаанбаатар-Дарханы цахилгаан дамжуулах шугамын угсралтын ажлыг хүлээн авахад Ерөнхий инженер Д.Жигжид агсны хамтаар оролцож явсан “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ”-г үүсгэн байгуулагчдын нэг юм.



ГЭМТЛИЙГ БҮРЭН УСТГАЖ, ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИНД ХОЛБОЛОО

Энэ сарын 13-ны өдрийн 22.40 цагаас 23.10 цагийн хооронд Архангай аймгийн Хашаат сумын нутгаар хүчтэй аадар бороо орж, 27 м/сек хүчтэй шороон шуурга шуурсны улмаас Хархорин дэд станцаас 40 км орчим зайд 110 кВ-ын Хархорин А, Хархорин Б цахилгаан дамжуулах агаарын шугамын 679-683 дугаар хүртэл тулгуур (ПБ110-8 маркийн 5 ширхэг төмөр бетон) хугарч, 7 аймаг, 57 сумдын 45320 хэрэглэгч, 5256 аж ахуйн нэгж цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан.

110 кВ-ын Хархорин А, Хархорин Б цахилгаан дамжуулах агаарын шугамын гэмтэл устгах, сэргээн засварлах ажлыг 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 06.37 цагаас 08 дугаар сарын 15-ны өдрийн 17.34 цагийн хооронд ЦДҮС ТӨХК-ийн Улаанбаатар, Хангайн бүсийн салбарын нийт 96 ажилтан, 24 техник хэрэгсэлтэйгээр 43 цагт амжилттай гүйцэтгэж, хязгаарлагдаад байсан хэрэглэгчдийг төлөвлөсөн хугацаанаас өмнө цахилгаан эрчим хүчинд холболоо.




**2023 ОНЫ
КОМПАНИЙН АВААР
СЭЭРГҮҮЦЭХ ДАСГАЛЫГ
ЗӨВС-Т 08 ДУГААР
САРЫН 25, 26-НЫ
ӨДРҮҮДЭД ЗОХИОН
БАЙГУУЛАВ.**

“Зүүн-Өмнөд бүсийн салбарын Багануур д/ст 110 кВ-н Хот-А АШ-д гэмтэл гарч хамгаалалт ажиллаж, Багануур д/ст-д таслуур тасраагүй татгалзсан үед авах арга хэмжээ” сэдвээр ШЗХ-ийн ахлах диспетчер М.Өмөрбай, диспетчер инженер Б.Батжаргал, Б.Баттулга, С.Сэд-Аюуш, Б.Ариунболд нар зохион байгууллаа.

Тус АЭД-д тухайн салбарын 5 диспетчер инженер, Багануур д/ст-ын ээлжийн 7 ажилтан, Хот д/ст-ын ээлжийн 8 ажилтан, Төв д/ст-ын ээлжийн 6 ажилтан, нийт 26 хүн хамрагдсан. АЭД-д оролцсон шуурхай ажиллагааны ээлжийн ажилтан тус бүрээс тестийн шалгалт авч, сэлгэн залгалтын хуудас бичүүлж, дүгнэсэн. Мөн шуурхай ажиллагааны хүмүүстэй АЭД талаар хуралдаж, шуурхай ажиллагааны алдаа, зөрчил гаргахгүй цаашид хэрхэн ажиллах талаар хэлэлцүүлэг хийсэн.





УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр зохион байгуулав

Сар бүрийн 2 дахь долоо хоногийн мягмар гарагт зохион байгуулагддаг "Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр"-ийг 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр салбарын хэмжээнд зохион байгуулсан. Тус өдрөөр 1-р төв эмнэлгийн мэдрэлийн эмч Н.Түмэндэмбэрэл салбарын ажилтнуудын 2023 оны эрүүл мэндийн үзлэгийн талаар танилцуулга хийж, төв удирдлагын Хяналт мониторингийн хэлтсийн ахлах бөгөөд техникийн хяналтын инженер Я.Мөнхтөр, ХАБЭАИ Б.Батчулуун нар "Технологийн зөрчлийн талаар" сургалт явуулсан.



"Хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр"-ийн үеэр

Дэд станцуудын өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх гадны байгууллагын ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллаж байна.

Үүнд: ИХБ-3, Улаанбаатар, Улаанхуаран дэд станцуудад РХА-ийн хоёрдогч хэлхээний шинэчлэлийн ажил гүйцэтгэх Монхорус ХХК, Цэвэрлэх дэд станцын шинэчлэлийн ажил гүйцэтгэж байгаа Вилл Вест ХХК, Умард дэд станцын барилгын дээврийн засварын ажил гүйцэтгэх Тост өргөө ХХК, Яармаг дэд станцын аккумуляторын байгууламжийн шинэчлэлийн ажил гүйцэтгэх Дорнод газар ХХК, Дорнод-2, Дулаан дэд станцын РХА-ийн хоёрдогч хэлхээний шинэчлэлийн ажил гүйцэтгэх МСЭЛ ХХК, Сонгино дэд станцын хамгаалалтын зурваст их чадлын хуримтлуурын ажил гүйцэтгэх Смарт плас ХХК, 110 кВ-ын өргөтгөлийн ажлаар тоноглолуудын суурийн ажил гүйцэтгэх Сора Хашира ХХК, Хөшигт дэд станцын өргөтгөлийн ажил гүйцэтгэх Илч хангай ХХК, 109,110-р агаарын шугамын трасс өөрчлөх ажлын хүрээнд монопол тулгуурын суурийн ажил гүйцэтгэх Альфа инженеринг ХХК-ийн ажилтнуудад тус тус аюулгүй ажиллагааны тухайлсан зааварчилгаа өгч, ажлын явцад хяналт шалгалт хийж аюулгүй ажиллагааг хангуулж ажилласан.

Хамгаалалтын зурвас

Хамгаалалтын зурваст ажиллах гадны байгууллагын ажилтнуудад зааварчилгаа өгч, зарим ажлуудад тасралтгүй хяналт тавьж ажиллаж байна.



110 кВ-ын Дундгол, Гео агаарын шугамын хамгаалалтын зурваст ажил гүйцэтгэх МЭЗ ХХК-ийн ажилтнуудад зааварчилгаа өгч байгаа нь

ЦДАШ-ын хамгаалалтын зурваст зөрчил гаргасан Монцемент билдинг материалс ХХК /211,212-р АШ-ын тул№19-20/, О&G ХХК /СХД 20-р хороо 18-131 Гео 118-р АШ-ын тул№17-18/-уудад мэдэгдэл өгсөн.

Сургалт, дадлага зохион байгуулав

Тус салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний албанд шинээр ажилд орсон болон инженер, техникчийн шалгалт өгөхөөр бэлтгэж байгаа ажилтнуудын сургалт батлагдсан хуваарийн дагуу 2023.06.16-22-ны өдрүүдэд Туул дэд станц дээр зохион байгуулж, нийт 25 ажилтан хамрагдсан.



Сургалтын явц

Нийт ажилтнуудад "Байгууллага доторх хүний эрхийн зөрчил, маргаан, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх" сэдэвт сургалтыг Хүний эрхийн үндэсний комисстой хамтран 2023.06.21-ний өдөр зохион байгуулж, сургалтад танхимаар 20 ажилтан, цахимаар 120 орчим ажилтан хамрагдан, мэргэжил арга зүйн зөвлөгөө авлаа.



Сургалтын явц

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ЦДҮС ТӨХК-ийн хэмжээнд анхны 110 кВ-ын монопол хийцтэй төмөр тулгуурыг суурилуулж ашиглалтад оруулав


ЦДҮС ТӨХК болон Эрдэм транс ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу Баянгол дүүргийн 20-р хороонд байрлах автобаазын хашаанаас 205, 206, 208, 109, 110-р АШ-ын тулгууруудыг гаргаж, трасс өөрчлөх ажил 2022 оноос эхэлсэн. Улаанбаатар салбар шугамын трассыг өөрчлөх ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд 109,110-р АШ-ын тул№13-14 хооронд БНХАУ-ын "Tianjin Jintong Steel Tower" Co.,Ltd компанид үйлдвэрлэгдсэн 1М-SJG3 маркийн 34.1 метр өндөртэй 110 кВ-ын монопол төмөр тулгуурыг 2023 оны 8-р сард суурилуулж ашиглалтад оруулав. Уг ажил нь ЦДҮС ТӨХК-ийн хэмжээнд монопол хийцтэй төмөр тулгуурыг анхлан ашиглалтад нэвтрүүлж байгаагаараа онцлог юм.

110 кВ-ын монопол тулгуурыг угсарч суурилуулах ажлыг дараах хугацаанд гүйцэтгэв.

- 2023 оны 08-р сарын 05-ны өдөр: Нэг өдрийн хугацаанд монопол тулгуурын 9 метр гүн суурийн нүхийг тусгай зориулалтын өрмийн механизмаар ухаж бэлтгэх, 1.5 метр диаметртэй төмөр бетон суурийг газар дээр нь цутгах ажлыг Альфа инженеринг ХХК гүйцэтгэсэн. Технологийн горимын дагуу уг суурийн бетоныг цутгалт хийснээс хойш 14 хоногийн хугацаанд бүрэн хатаасан.
- 2023 оны 08-р сарын 21-ний өдөр: Компанийн аж ахуйн хашаанаас тулгуурын хийц хэсгийг ялгаж ачих, угсралтын талбайд зөөвөрлөн хүргэх ажлыг гүйцэтгэсэн.
- 2023 оны 08-р сарын 22-ны өдөр: Засварын албаны дарга В.Мөнхбат, шугамын засварын мастер Д.Батбаяр нарын удирдлага дор 18 ажилтны бүрэлдэхүүнтэй бригад 4 цагийн хугацаанд 1М-SJG3 маркийн монопол тулгуурыг угсарч босгосон.

Монопол хийцтэй тулгуурын онцлог, давуу талуудаас дурдвал:

- Трассын зай талбай дутагдалтай газраар нэг тулгуураар олон хүчдэлийн түвшинтэй АШ-уудыг хамтад нь татах боломжтой.
- Дамжуулах сүлжээнд одоо ашиглагдаж байгаа уламжлалт хийцтэй тулгуураас өндөр.
- Суурийн хэсгийн эзлэх талбай бага. Зай талбай, газар чөлөөлөхтэй холбоотой асуудал байнга үүсдэг барилгажсан, хүн амын нягтрал ихтэй бүсэд илүү тохиромжтой.
- 2 тулгуурын хоорондох зай, алслалтын урт илүүтэй.
- Ашиглалтын хугацаа цайрдаагүй тулгуур 50 жилээс багагүй, цайрдсан бол 70 жил.
- Угсралт, суурилуулалтын хугацаа бусад төрлийн тулгуураас 2-3 дахин богино. Ажиллах хүчний тоо бага. (Хүн/цаг: 110 кВ-ын дундын монопол тулгуур нь СК-26 хөлтэй ПБ110 тулгуураас 5% бага, П110 тулгуураас 2.8 дахин бага)
- Газар шорооны ажлын хэмжээ 2 дахин бага.
- Монопол тулгуурыг буулгах, яаралтай үед зөөж шилжүүлэн угсрах хугацаа бага.
- Зөөвөрлөхөд хялбар. Энгийн тулгуураас бага жинтэй. Тээвэрлэлтийн зардал бага.
- Материалын зардал нь бетон тулгуураас 12-15%, төмөр торон хийцтэй тулгуураас 40-50% хэмнэлттэй.
- Сүүлийн жилүүдэд энгийн төмөр тулгууруудад хөндлөн хэрээс төмрийн боолт сулрах, хэрээс төмөр унах, хулгайд алдагдах асуудал гарах болсон. Монопол тулгуурт уг асуудал гарахгүй.
- Монопол тулгуур нь бусад төрлийн тулгууруудын адил анкер, завсрын, эргэлтийн гэх мэт төрлүүдтэй.
- Сэргээн засварлан буцааж ашиглах боломж нь бусад төрлийн тулгуураас илүү.
- Хадгалалтын нөхцөл нь хялбар. Бусад төрлийн тулгуур шиг хийц хэсгүүд нь холилдож хүндрэл үүсгэхгүй.



Төлөвлөгөөт графикийн дагуу дэд станцын тоноглолд 220/110 кВ-ын ИХБ-4-н 110 кВ-ын 20 нэр төрлийн тоноглол, 220/110/35 кВ-ын Улаанбаатар дэд станцын ДХТ-1,2, ЦДАШ-д 107,108-р АШ, 203,204-р АШ-ын тулгуур №190-170-н хооронд нийт 20 тулгуурын будгийн ажил, 23 нэр төрлийн их засварын ажил хийж гүйцэтгэсэн.



Улаанбаатар дэд станц ДХТ-1, 2

Эрдэм транс ХХК-тай байгуулсан гэрээт ажлын дагуу 109,110-р АШ-ын трасс шилжүүлэх ажлаар У110-2+5 маркийн анкер тулгуур босгох, У110-2 маркийн тулгуурын 2 ширхэг хөл суурилуулах, 205,206-р АШ-ын У220-2+9Т маркийн тулгуур №9-г буулгах ажлыг гүйцэтгэсэн.



У110-2 маркийн тулгуурын хөл суурилуулж байгаа

Байгалийн онц аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйлийн улмаас 110 кВ-ын Хархорин А,Б цахилгаан дамжуулах агаарын шугамд 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр болон 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр гарсан аваарыг богино хугацаанд устгах сэргээн босголтын ажилд Засварын албаны ажилтнууд идэвх зүтгэл, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажилласан.



Мэдээллийг бэлтгэсэн: Захиргаа, аж ахуйн албаны ахлах бөгөөд дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Т.Аюуш

ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2023.08.10-ны өдөр 110кВ Сүхбаатар АШ-ын тулгуур №01 хамгаалалтын бүсийн доор дулааны лоткин буулгасан зөрчил үзлэгийн үед илэрсэн. Уг ажлыг ЕСӨН ГАН ХХК хийснийг тодруулсан. 2023.08.11-ний өдөр ЗА-ны ахлах инженер Б.Анхбаяр хяналт тавьж дээш өргөлгүй по трактораар зөөвөрлөн хамгаалалтын бүсээс гаргаж трассын дагуу шилжүүлж зөрчлийг устгасан.



Илэрсэн зөрчил 2023.08.10



Зөрчлийг устгах үе
2023.08.11

Зөрчлийг устгасан
байдал

2023.08.10-ны өдөр 110кВ Ерөө АШ-ын үзлэгийн бригад тулгуур №216-217 хамгаалалтын бүсэд ажил гүйцэтгэж байсан зөрчлийг илрүүлсэн. ХАБЭА инженер Б.Наранбаатар, ЗА-ны ахлах инженер Б.Анхбаяр нар газар дээр нь очиж ажилласан. Бугант тосгоны зам засварын ажлын хүрээнд ЕСӨН ЭРДЭНЭ ХХК хайрга чулуу ухаж зөөвөрлөх ажил хийж байсныг зогсоосон. Мөн Бугант тосгоны Байгаль орчны хяналтын улсын байцаагч Д.Мөнхбат, ЕСӨН ЭРДЭНЭ ХХК –ийн газрын даамал Д.Гантөмөр нарт хамгаалалтын зурваст ажиллах дүрэм журам, ЭХ-ний хууль зэргийг танилцуулж протокол хөтлөн дахин дураараа ажиллахгүй байх талаар Сэлэнгэ аймаг Ерөө сум Бугант тосгоны захирагчийн албанд хамтран ажиллах албан бичиг өгч ажилласан.



Илэрсэн зөрчил 2023.08.10



Зөрчлийг устгасан байдал

110кВ-ын ЕРӨӨ АШ-д төлөвлөгөөт ТЗБАХ, ИЗ –ын ажлыг 2023.07.18-21-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

ХАБЭА орон тооны бус зөвлөлөөс 2023.08.18 өдөр автомашингүй өдрийг зохион байгуулав. Уг арга хэмжээнд бүх ажилчид идэвх санаачилгатай оролцов.

1. 220кВ-ын 208-р АШ-ын тасралтын



зоонд үзлэг хийж, үзлэгээр илэрсэн Ту№212 Аф гярландаараа нэвт цохигдсоныг, Ту№213-ын Аф-ын хөндийрүүлэх элемент 2ш нэвт цохигдсоныг тус бүр сольж, 201-р АШ-ын Ту№153 Вф-н элемент гярландаараа нэвт цохигдсоныг сольж гэмтэл устгалтын ажил гүйцэтгэсэн.

2. 2023 оны 08 сарын 11-ний 02/1165



тоот албан бичгийн дагуу нийт нутгаар байгалийн онц аюултай үзэгдлийн давтан болж бороо, салхи, байгалийн нөлөөллөөс шугам тоноглол тэдгээрийн суурь, хөрсөнд ихээхэн эвдрэл үүсэж тулгуур хазайх, голын гольдролд өөрчлөлт орж тулгуур усанд автах гэмтлүүд гарахаас урьдчилан сэргийлэх ИТА-н үзлэгийг салбарын 110, 220 кВ-н ЦДАШ-нд 8 сарын 17, 18-нд 4 бригад болон хуваагдаж 2 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Үзлэгээр илэрсэн гэмтэл зөрчлийг 2024 оны төлөвлөгөөнд тусгаж оруулав.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

2023 оны ТЗБАХ-ын ажлын хүрээнд 110/35/6 кВ-н ЗҮҮНХАРАА дэд станцад Т-1,2 –ын Са.С болон 110/35 кВ-ын цэнэг шавхагчийг бүрэн шинэчлэх ажлыг М.Норовсамбуугийн бригад 2023.08.26-27-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний дагуу 110кВ-ын 6, 35кВ-ын 6, Са.С-ын 2 нийт 14 цэнэг шавхагчийг сольсон.



ТЗБАХ-ын ажлаар 110кВ-н Ерөө ЦДАШ-н тулгуур №136, 214, 258-р СК-22 маркын тулгууруудыг солих эзлэхүүнтэй ажлыг УБ хотоос СК-22 маркын 3 тулгуурыг зөөвөрлөн солих трассын дагуу байрлуулж графикт хугацааны дагуу ЗА-ны АШ-н мастер Б.Саранболдын бригад 8 хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн. Ерөнхий инженер М.Чулуунбаатар, ХАБЭА инженер

Н.Ууганбаяр нар газар дээр нь удирдан зохион байгуулж хяналт тавьж ажилласан.



Доод хэсгээрээ хагарч цуурсан мөн их бие нь цууралттай унахаас урьдчилан сэргийлж түр зуурын арга хэмжээ авсан байсан тулгууруудын зөрчлийг ийнхүү устгаж хэвийн болголоо.



ИХ ЗАСВАР-ын ажлын хүрээнд 110 кВ-ын Ерөө АШ-ын ИЗ-ын ажлаар нийт 40 тулгуурт 960 ширхэг элемент солих ажлыг АГТ-ний хүрээнд бүрэн гүйцэтгэсэн. Үүнд тулгуур №139, 140, 155-167, 158-182 тулгууруудад ПСВ-70 маркын тусгай зориулалтын элемент солих болон 50 тулгуурт шувуу үргээгч суурилуулах ажлыг ЗА-ны АШ-н монтёр Ш.Батдоржийн бригад графикийн дагуу ажиллаж засварын

ажлыг хийж гүйцэтгэсэн.


2023 оны 110/35/6кВ-н Зүүнхараа дэд станцын ИЗ-ын ажлын хүрээнд 110кВ-ын шинний элемент солих ажлыг 2023.07.26-27-ний өдрүүдэд Б.Саранболдын бригад хийж гүйцэтгэсэн. Нийт 975 элемент сольсон. Ажлын аюулгүй байдалд ХАБЭА инженер Б.Наранбаатар хяналт тавьж ажилласан.



ИЗ-ын ажлын хүрээнд 116-р АШ-ын тулгуур будах ажлыг Шугамын мастер Б.Саранболдын бригад 2023.07.28-31-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний дагуу нийт 175 тулгуурын траверс будсан.



Мэдээллийг бэлтгэсэн:
Захиргаа, аж ахуйн албаны
дарга Б.Баяр



ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 07, 08 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Ээлжит шалгалт: Салбарын хэмжээнд шинээр ажилд орсон болон албан тушаал өөрчлөгдсөн 22 ажилтанд дагалдан суралцах программ гарган өгч шалгалтын комисс тухай бүрд нь шалгалтуудыг авч 16 ажилтныг жинхлүүлэн, 5 ажилтанд шинээр групп олгон, 1 ажилтны группыг ахиулсан байна.

Наряд, шийдвэрээр хийсэн ажил: Салбарын харьяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыдаар 56, шийдвэрээр 117 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 509 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.

Дасгал, зааварчилгааны талаар: Шинээр ажилд орсон 3 ажилтанд урьдчилсан зааварчилгаа, 151 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгаа, 1033 ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, 123 ажилтанд сар бүрийн ээлжит зааварчилгаа, ээлжит бус зааварчилгааг 240 ажилтанд, тухайлсан зааварчилгааг 509 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 20 удаа хийгдэж нийт 67 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 2 удаа хийгдэж нийт 10 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 2 удаа хийгдэж нийт 29 ажилтан тус тус хамрагдсан байна.

ХАБЗА-н бүх шатны үзлэг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 44 удаа хийж 72 зөрчил, II шатны

үзлэгийг 8 удаа хийж 18 нэрийн зөрчил, III шатны үзлэгээр илэрсэн 13 зөрчлийг устган нийтдээ 100 зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажиллалаа.

Бусад ажлын талаар: Үндэсний их баяр наадмын үеэр хариуцлагатай жижүүрүүд томилогдон ажиллаж аваар, саатал, гэмтэл зөрчил, тасралт саатал гаргалгүй ажилласан.

Салбарын конторын галын хорнуудыг жигдрүүлэн зохих хэмжээнд нь байрлуулан, галын гарцын тэмдэг, тэмдэглэгээг зохих түвшинд нь оруулж тавьсан.

Эрчим хүчний салбарын улсын ерөнхий байцаагчаас ирүүлсэн албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу хийгдсэн тайланг ХМХ-т YIII/7-ны өдөр хүргүүлсэн.

Өвөрхангай аймгийн ОБГ-ын гал

түймрийн улсын хяналтын байцаагчийн албан шаардлагын дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг VIII/10-нд, Булган аймгийн ОБГ-ын хариуг VIII/17-ны өдөр тус тус хүргүүллээ.

2023-08-13-ны өдөр 110кВ-ын ХХ-А,Б ЦДАШ-нд гарсан аваарын үеэр газар дээр нь очиж ажиллан бүх талын хяналтыг тавьж, тухайлсан зааварчилгааг давхардсан тоогоор 130 ажилтанд өгөн, мэдээ мэдээллийг ГХШ-т тухай бүрд танилцуулан, акт, илтгэлүүдийг гарган, АА, ХХ-ын зөрчилгүй, гэмтлийг 42:39 цагийн хугацаанд устган амжилттай залгалаа.

Гал эсэргүүцэх инженер техникийн комисс, галын аюулгүй байдлыг хариуцагч нар, галын сайн дурын бүлгэмийг томилох тухай тушаалын нэмэлт өөрчлөлтүүдийг хийн YIII/ 11-ний өдөр шинэчилсэн.

Зуны нормын хувцаснууд болон өвлийн нормын гуталнуудыг бүх алба хэсгүүдэд хуваарилалтыг хийн YIII/24-ний өдөр олголоо.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

- Их засварын тодотгосон төлөвлөгөөний дагуу нийт гүйцэтгэл 74 нэр төрлийн ажлаас 53 ажил хийгдсэн 72 %-тай байна.

- Урсгал засвараар 85 нэр төрлийн ажлаас 76 нэр төрлийн ажил хийгдсэнээр 91 %-тай байна. Үүнд:

- Мөрөн, Булган, Тосонцэнгэл, Хишиг-Өндөр дэд станцын тоноглолуудад төлөвлөгөөт их болон урсгал засваруудыг хийсэн.

- ТЗБАХ-ний тодотгосон төлөвлөгөөний дагуу 14 нэр төрлийн ажлаас 4 ажил хийгдэж 33.3 %-тай тус тус гүйцэтгэсэн. Үүнд:

- Булган, Сансар дэд станцуудад камер суурилуулах ажлыг хийсэн.
- 110 кВ-ын Баянхонгор АШ-ын РХА-ийн байгууламжийг шинэчилсэн.

Булган,
Сансар дэд
станцуудад
камер
суурилуулсан
байдал



110 кВ-ын Баянхонгор
АШ-ын РХА-ийн
байгууламжийг
шинэчилсэн байдал

Мэдээллийг бэлтгэсэн: Захиргаа,
аж ахуйн албаны сургалт
бүтээмжийн инженер Б.Ундрах

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2023 оны эхнээс урьдчилсан зааварчилгаанд шинээр ажилд орсон 22 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 1111 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 1276 ажилтан, тухайлсан зааварчилгаанд 2322 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 13489 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

“Хамгаалалтын зурвас”-ын дэглэм сахиулах аяны хүрээнд Багануур дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 207-р АШ-н ТН№13, 14-ийн дундах хамгаалалтын зурваст барилга байгууламж барих ажил эхлүүлсэн хувь хүн, аж ахуй нэгжид 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Багануур дүүргийн засаг дарга, дүүргийн ИТХ-ын дарга нарт хамтран ажиллаж зөрчил арилгуулах тухай ерөнхий инженерийн 02/270, 02/271 тоот албан бичгийг хүргүүлэн ажилласан.



220 кВ-н Бөөрөлжүүт АШ-н барилга угсралтын ажил, 207-р АШ-н их засварын ажил, тулгуурын траверсыг зэврэлтээс хамгаалж боронздож будах, ажлыг гүйцэтгэх Багануур, Чойр хэсэг, Сайншанд дэд станцын нэгдсэн бригадын 28 ажилтанд тухайлсан зааварчилгаа өгч машин механизмтай ажиллах үеийн аюулгүй ажиллагааг хангуулж тогтмол хяналт тавьж ажилласан.



2023 оны 04 сарын 26-ны өдөр “МАНЧИМ” ХХК ПРОТЛАБ онош зүйн лабораторитой гэрээ №34-г байгуулан салбарын 2023 оны ХАБЭА-н төлөвлөгөөний дагуу 126 ажилтныг 2023 оны 05 дугаар сарын 27-ноос 06 дугаар сарын 04-ний хооронд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулан дүгнэлт гаргуулсан. Эрүүл мэндийн хувьд анхаарах 3-р шатлалын буюу эмнэлэгт үзүүлэх

шаардлагатай ажилтнуудын дүгнэлтийг үндэслэн нарийн мэргэшлийн эмчид хандах үүрэг өгсөн. Үлдсэн 70 ажилтан 2023 оны 08 дугаар сарын 28-наас эхлэн харьяа орон нутгийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэг оношлогоонд хамрагдаж байна.



Салбарын харьяа дэд станцуудын ил хуваарилах байгууламжийн зэрлэг өвс, ургамал хадаж цэвэрлэх, кабелийн лотки цэвэрлэж галын аюулгүй байдлыг хангуулах ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах үүрэг даалгавар өгч ажилласан ба гүйцэтгэл 70%-тай байна.



220 кВ-н Бөөрөлжүүт ЦДАШ-н Багц-1 барилга угсралтын ажлын хүрээнд АН№1, ТН№2, 3-ын суурийн нүх ухах ул тавих, хөл тавих, нягтруулга хийж буцаан булах засах, анкер тулгуур, завсрын тулгууруудыг угсрах, чангалгаа хийж босгох, утас татах, газардуулга хийж гүйцэтгэх нийт 62 инженер техникийн ажилтан, 15 машин механизмд тогтмол хяналт тавьж нэгдсэн бригадуудад тухайлсан зааварчилгаа өгч, хяналт тавин, захиалагч талаас ирүүлсэн албан шаардлагын биелэлтийг тухай бүр гаргаж хүргүүлэн ажилласан байна.

Бор-Өндөр дэд станцын ил хуваарилах байгууламжийн зэрлэг өвс хадах мөн ил хуваарилах байгууламжид үүрлэсэн үхэр оготно устгах, хоёрдогч хэлхээний кабелийн туннель лоткинд өвс тэжээл, хөөө нөөцөлснийг цэвэрлэв.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын ажлын мэдээ: Он дамжин хийгдэж байгаа Чойр дэд станцын Р-1, Р-3-н радиаторыг шинээр хийх трубаг тастаж матах ажлын гүйцэтгэл 60 хувьтай хийгдэж байна.


- 2023 оны тодотгосон төлөвлөгөөт их засварын 18 ажлаас / 258,97 сая төг /14 ажил хийгдэж гүйцэтгэл 72,7 хувьтай.
- 2023 оны тодотгосон төлөвлөгөөт ТЗБАХ-н 20 ажлаас /3,563,3/ 9 ажил хийгдэж 45 хувьтай.
- Хөрөнгө оруулалтын ажлаар 10 ажлаас /283,0/5 ажил хийгдэж 50 хувьтай.
- 2023 оны төлөвлөгөөт урсгал засварын 87 ажлаас 84 ажил хийгдэж 96 хувьтай.
- АТД ажлаар 121 ажлаас давхардсан тоогоор 163 ажил хийгдсэн.
- Аянгын улирлын бэлтгэл ажлын 26 ажлаас 26 ажил хийгдэж 100 хувьтай.
- Гэмтэл устгах ажил өссөн дүнгээр 48 ажил хийгдсэн.



Мөн 220 кВ-н Бөөрөлжүүт АШ-ын БУА-ыг ажлын графикийн дагуу гүйцэтгэж байна. Шугамын угсралтын ажлын гүйцэтгэл 65%-тай байна.

Багануур дэд станцын өргөтгөлийн ажлыг 2023 оны 10-р сарын 01-нд дуусгахаар ажил гүйцэтгэх график төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ ажилтай холбоотой УБС-с ирсэн 3ш шугамын порталын хөл, 2ш шиний порталын хөл, 6ш порталын траверс, 4ш порталын татуурганы хөндрүүлэгч, 6 ш ригель буулгаж хүлээж авсан. Чойр дэд станцын 220кВ ИХБ-ийн бэлтгэл гаргалгааны тоноглолуудыг буулгаж Багануур дэд станцруу зөөж тээвэрлэх ажил хийгдэж байна.

Мэдээллийг бэлтгэсэн: Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны өндөр үелзлэлийн холбооны инженер Н.Одхүү



ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2023 оны 07, 08 дугаар сард нарыдаар 56, шийдвэрээр 117 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд аюулгүй байдлыг онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 18 удаагийн дасгал зохион байгуулагдаж 122 ажилтан хамрагдсан. Сарын давтан зааварчилгааг 138 хүн, тухайлсан зааварчилгааг 397, ээлжит бус зааварчилгааг 143 ажилтанд өгсөн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 457 удаа хийж 22 зөрчил, II шатны үзлэгийг 24 удаа хийж 45 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллалаа. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 26 удаа хийсэн.

Шугам тоноглолын найдвартай ажиллагааг ханган ажиллах тухай Говийн бүсийн салбарын даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/33 дугаар тушаалын дагуу хариуцлагатай жижүүрүүд ажилласан.

2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 08:00 цагаас 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цаг хүртэл: Салбарын инженер

техникийн 12 ажилтан хариуцлагатай жижүүрээр батлагдсан хуваарийн дагуу дэд станцуудын горим схемийн байдалтай танилцан хариуцлагатай жижүүрийн журнал хөтөлж, компанийн хариуцлагатай жижүүрт салбарын үйл ажиллагааны мэдээ өгч, google doc-т мэдээллийг тогтсон хугацаанд оруулан, дэд станцуудад галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэж ажилласан.

Дундговь аймгийн төвд 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдөр орсон түр зуурын аадар борооны улмаас аймгийн төв бохирын



шугам усаар дүүрч, улмаар салбарын оффисын байрны В1 давхар 20:35 цагийн үед усанд автсан. Тухайн үед бэлэн байдлыг ханган ажиллаж байсан цоохор бригад болон холбогдох ажилтнуудыг дуудаж, усыг шавхах ажлыг салбарын 10 хүнтэй бригад 21:20-00:12 цагийн хооронд ус соруулах насос ашиглан шуурхай зохион байгуулж ажилласан.

Үерийн усны улмаас оффисын барилга, холбоо болон дулаан, цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжид учирсан хохирол байхгүй.



Үерийн усыг зайлуулсан талбайд 07 дугаар сарын 11-ний өдөр 18:30-19:10 цагийн хооронд ариутгал хийх ажлыг зохион байгуулсан.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцын гүний худгийн насос гэмтсэнийг 2023 оны 07 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд дэд станцын засварын монтер А.Дорждэрэм, гагнуурчин Э.Дөлбадрах, жолооч Б.Бат-Эрдэнэ нар засварлаж насосыг сольж тавьж хэвийн ажиллагаанд оруулсан.



2023 оны 03, 04 дүгээр сард болсон хүчтэй шороон шуурга, усархаг борооны улмаас тулгуур № 520,478, 652, 618, 612, 505, 504, 503, 502, 501, 494 хазайсан гэмтэл илэрсэн. Уг гэмтлийг засварлах ажлыг 2023 оны 07 дугаар сарын 03-08 өдрүүдэд 5 машин механизм, 13 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.



Баяр наадмын өмнөх үзлэгийг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр 215:216-р агаарын шугамд зохион байгуулсан. Тус үзлэгээр тулгуур №110 дээр боолт гайк дутуу, суларснаас PS-220/2 маркийн тулгуур гулзайсан гэмтэл илэрсэн. Уг гэмтлийг 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр устгах ажлыг зохион байгуулсан. Гэмтэл устгах засварын ажлыг гүйцэтгэхэд компаниас 100тн автокраныг авч 3 механизм, 21 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн. Үүнтэй ижил төстэй гэмтэл гарч болзошгүй учир 215:216, 217:218-р агаарын шугамд бүх тулгуурт траверсаас доош боолтны чангалгаа хийх ажлыг 15 хүний бүрэлдэхүүнтэй бригад гүйцэтгэсэн.



Сонгино-Мандалын чиглэлийн 330 кВ-н овортой 213:214-р агаарын шугамын урсгал засвар, трасс цэвэрлэх ажлыг 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр 8 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.



220/110/35/10 кВ Тавантолгой дэд станцад тусгаарлах автоматик/ДА/-г ажилд оруулсан бөгөөд тус автоматикийг оруулснаар нэгдсэн системтэй холбогдож байгаа 215, 216-р агаарын шугам тасрах үед Ухаахудаг ЦС, Цэций СЦС, Даланзадгад ДЦС-уудын үндсэн тоноглолуудыг хамгаалах, эх үүсвэрүүдийг баланслагдсан ачаалалтай тусад нь гаргах юм.

215, 216, 217, 218-р агаарын шугамын ӨДП-н тохиргоог үйлдвэрлэгч байгууллагаас ирсэн мэргэжилтнийн хамт хийсэн бөгөөд 215 болон 216-р агаарын шугамын үндсэн хамгаалалтын ажиллагааг хэвийн болгосон.



110 кВ Даланзадгад агаарын шугамын ӨДП-ний доторх преом сигналын реле гэмтсэн бөгөөд тухайн гэмтлийг устгаж ӨДП-н ажиллагааг хэвийн болгож үндсэн хамгаалалтыг оруулсан.

Тавантолгой дэд станцад 220/110/35 кВ -н I, II СШ-үүдэд грамоникийн хэмжилтийг хийж өвлийн оргил ачааллын үед горимын тооцоо гаргах мөн Цэций СЦС-н трансформаторт хэвийн бус дуу чимээ гарсныг тодруулах зорилгоор хийгдсэн.



ДҮТ ТӨХХК болон РХАХТХ-тэй хамтран 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Мандал, Тавантолгой дэд станцуудад 215,216-р агаарын шугамын шууд болон тэг дарааллын эсэргүүцлийг OMICRON CPC-100 багажаар хэмжив. 215, 216-р агаарын шугамын эсэргүүцлийг тооцооллын аргаар гаргаж хэрэглэж байсан. Тухайн шугамд эсэргүүцлийн хэмжилт хийгдсэнээр тооцооллын арга болон бодитоор хийсэн эсэргүүцлийн хэмжилт хоёрын утгын зөрүү харагдах юм. Мөн эсэргүүцлийн хэмжилт хийгдсэнээр 215, 216-р шугамд гэмтэл гарсан үед гэмтлийн цэгийг илүү найдвартай тодорхойлох боломжтой болно.



Мэдээллийг бэлтгэсэн: Захиргаа,
аж ахуйн албаны албаны дарга
Ц.Ганнягт

ТӨВ УДИРДЛАГА

Өвлийн их ачаалал давахын тулд ачаалал хөнгөлөх автоматжуулсан системийн сүлжээ үүсгэх ЦДҮС ТӨХК, ДҮТ ТӨХХК, УБЦТС ТӨХК компаниудын Хяналт мэдээллийн системийг интеграци хийх ажил хийгдэж байна

SCADA-Хяналт мэдээллийн систем. Системийн үндсэн нь компьютер бөгөөд үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагааг удирдах, хянахад ашиглана. Энэ систем нь эрчим хүчний салбарт цахилгаан хэрэглээ, үйлдвэрлэлийн ажиллагааны тоноглолууд, тэдгээрийн төлөв байдлын талаарх мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийхэд ойлгомжтой байдлаар харуулахад ашиглана. Систем нь инженер техникийн болон шуурхай ажиллагааг удирдан зохион байгуулдаг ажилтнуудын үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх, аюулгүй ажиллагааг хянах зорилготой.

Ихэвчлэн СКАДА нь ямар нэгэн программ хангамжийн тусламжтай мэдээлэл цуглуулах тэдгээрийг боловсруулж, шуурхай ажиллагааны схем болгон шуурхай ажиллагааг бүрэн удирдахад хялбаршуулан дэлгэцэнд харагдахуйц болгоно. Мөн алсаас удирдах бололцоогоор бүрэн хангагдсан.

ЦДҮС ТӨХК -ийн хувьд ZENON, Power SCADA зэрэг ОУ-д туршигдсан программ хангамжийг УБС болон ТБС-т ашиглаж байгаа бөгөөд эдгээрээс ZENON программ хангамжийг ДҮТ ТӨХХК, УБЦТС ТӨХК-д ашиглаж байна. Тиймээс 2023 оноос гурван компанийн түвшинд харилцан мэдээлэл солилцон SCADA бий болгох зорилготой ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 07 сарын 03-ны өдрийн А/177 дугаартай ажлын хэсэг байгуулах тушаал гарсан.



2023 онд SCADA оруулахаар төлөвлөсөн дэд станцууд:

- 110/35/10 кВ-н Найрамдал
- 110/10 кВ-н Хөшигт
- 110/35/10 кВ-н Сэлбэ
- 110/10 кВ-н ИлчБаян
- 110/10/6 кВ-н Умард
- 110/10 кВ-н Баруун
- 110/10 кВ-н Амгалан
- 110/10 кВ-н Дулаан
- 110/35/10 кВ-н Арцат
- 110/35/10 кВ-н Ташгай
- 110/10/6 кВ-н Дундгол
- 110/10/6 кВ-н Өмнөд

Эдгээр дэд станцыг нэн тэргүүнд оруулахаар сонгосон шалтгаан нь:

- Тоноглолын хувьд шинэ дэд станцууд учир системд мэдээлэл авах техникийн боломжийг хангасан
- Улаанбаатар хотын ачаалал ихтэй төвийн дэд станцууд нь доорх УБЦТС ТӨХК-н РП-ууд тэжээгддэг
- УБЦТС ТӨХК-н ашиглалтын нийт 68 Р, 200 гаруй реклоузериин мэдээллийг нэгтгэх бололцоотой
- ДҮТ ТӨХХК нь манай компанийн дараах дэд станцуудын мэдээллийг СКАДА системдээ оруулсан байгаа бөгөөд 3 компанийн СКАДА системийг интеграци хийснээр эдгээр дэд станцын мэдээллүүдийг шууд авах бололцоо бүрдэнэ.

- ИХБ-4
- ИХБ-3
- Дархан д/ст
- Эрдэнэт д/ст
- Сонгино д/ст
- Улаанбаатар д/ст
- Чойр д/ст
- Мандал д/ст
- Туул
- Налайх
- Шонхор

- Дорнод-2
- Баянчандмань
- Борнуур
- Зүүн хараа
- Тавантолгой


Уг ажлын хүрээнд одоогийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- SCADA үүсгэх бүтцийн схем боловсруулсан
- SCADA үүсгэхэд шаардлагатай ажлын даалгавар боловсруулах, 2023 оны тодотголд тусган тендер зарлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- 2023 онд SCADA-тай холбох 12 дэд станцуудын схем зургийг боловсруулсан.
- Улаанбаатар салбарын шилэн


кабель орсон 27 дэд станц дээр редантант байдлыг хангасан технологийн болон гадаад сүлжээ үүсгэх шийдэл гаргасан.

- Улаанбаатар салбарын дэд станцуудыг холбосон шилэн кабелийн сувгийн судалгаа хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 - Кабелийн унтралтын хэмжилт
 - Гэмтэлтэй шилэн кабелийн суваг тодорхойлох
 - Ашиглагдаагүй суп шилэн кабелийн сувагчлал байгаа эсэхийг тогтоох


Улаанбаатар салбарын дэд станцуудыг холбосон сүлжээний ерөнхий схем



Цаашид манай компани 5 салбарын 82 дэд станцыг холбосон сүлжээ үүсгэж. SCADA холбож өөрийн гэсэн биеэ даасан цогц хяналт мэдээллийн системтэй болох зорилготой ажиллаж байна.



Мэдээллийг бэлтгэсэн: МТХ-ийн компьютерийн ашиглалтын инженер Ш.Аюурзана



Дурдмал

Энэ оны өнгөрөгч 06 дугаар сарын 25-ны өдрийн 18 цаг 37 минутад Булган-Хархорин чиглэлийн 110 кВ-ын 24 ширхэг тулгуур унасан. Тус гэмтлээс үүдэж Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудын 82 сум цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан. 110 кВ-ын Булган-Хархорины агаарын шугамын барилга угсралтын ажлыг 1981 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 1984 оны 10 дугаар сарын 10-ны хооронд Цахилгаан

шугам сүлжээний барилга угсралтын контор хийж гүйцэтгэсэн бөгөөд олон жилийн насжилттай тулгуурын бүсэд аадар бороо орж, хүчтэй шуурсаны улмаас энэхүү нөхцөл байдал үүссэн. 110 кВ-ын Хархорин А, Б цахилгаан дамжуулах агаарын шугамын 463-486 дугаар хүртэл тулгуур (ПБ110-8 маркийн 24 ширхэг төмөр бетон) хугарч, тэдгээрийн дамжуулагч утас, аянгын тросс, изолятор, траверсууд бүрэн гэмтсэний улмаас 50719 хэрэглэгч, 6068 аж ахуйн нэгж цахилгаан эрчим хүчээр хязгаарлагдсан.



Гэмтэл саатлыг цаг алдалгүй сэргээн засварлах ажилд Өвөрхангай аймгийн Хархорин, Булган аймгийн Гурванбулаг сумын ЗДТГ болон Онцгой байдлын комисс, ЦДҮС ТӨХК-ийн Хангайн бүсийн салбар, ЭХЯ, Эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай, "ДҮТ" ТӨХК, "MCS Эрчим сүлжээ" ХХК, "Ричвелл" ХХК, болон хувийн аж ахуйн нэгж, иргэд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлснийг дурдах нь зүйтэй. Өмнө нь гэмтэл саатал үүсэж байсан ч энэ удаагийнх шиг олон тооны тулгуур нэгэн зэрэг унаж байсан нь үгүй. Хэдийгээр байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр үүссэн гэмтэл ч гэлээ олон жилийн насжилттай тулгууруудыг үе шаттайгаар солих цаг нь болсон гэдэгт дамжуулах сүлжээний инженерүүд санал нэгтэй байгаа юм. Тус гэмтлийг устгах, сэргээн засварлах ажлыг мэргэжилтнүүд 7 хоногт багтааж гүйцэтгэхээр төлөвлөсөн ч 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 15.44 цагаас 06 дугаар сарын 29-ний өдрийн 20.32 цагийн хооронд 39 машин техник, механизм, 155 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр 100 цаг 52 минут буюу 4 хоногийн хугацаанд амжилттай хийж, төлөвлөсөн хугацаанаас

өмнө хязгаарлагдаад байсан хэрэглэгчдийг эрчим хүчинд холбосон билээ. Жараад жилийн түүхийг өртөөлсөн дамжуулах сүлжээний хамт олон арвин их туршлага, сэтгэл зүтгэл, хүч хөдөлмөрөөрөө саад бэрхшээлийг даван туулж гэмтэл саатлыг устгасан гэдгийг цохон тэмдэглэе. Илч гэрлийн салбарын өндөр хариуцлагын өмнө дамжуулах сүлжээний бат бэх шугам, цэх тулгуур, ган судас болсон инженер техникийн ажилтнуудын ажлын ачаалал, хүнд нөхцөлд ажиллах эрсдэлийг энгийн иргэд төдийлөн сайн мэдэхгүй ээ. Гэвч, тэд алдар нэр, шагнал гавьяа горилж явах нь үгүй бөгөөд өсөн нэмэгдэж байгаа цахилгаан эрчим хүчийг тасралтгүй, найдвартай дамжуулах амин үүргээ нэр төртэй биелүүлж, эгэл ардын дундаа тэдний адилаар аж төрж байдаг чимээгүй баатрууд юм. Зургаан аравны түүхээ мөдхөн дархалж, ололт амжилт бүхнээ тэмдэглэх "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-аар овоглодог хэн бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсье!


**Захиргаа удирдлагын хэлтсийн
хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах
мэргэжилтэн Д.Энхбаяр**



2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр тухайн газарт хэвлэл мэдээллийнхэн очиход ЦДҮС ТӨХК-ийн Ерөнхий инженер Б.Эрхэмзаяагаар ахлуулсан ажилтнууд хугарсан тулгууруудыг цэвэрлэх, траверс угсрах, шинээр суулгах тулгуурын нүх ухах, изолятор хэлхэх, дамжуулагч утсыг засварлах бөгөөд олон машин механизмын дуу нүргэлж, чөлөө завгүй ажиллаж байв. Мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн дамжуулах сүлжээний инженер техникийн ажилтнууд тулгууруудыг шинээр суурилуулахад тун шуурхай ажиллаж байлаа. Салбар бүрээс ирсэн шугамын монтерүүд үнэхээр сүр жавхлантай. Зүйрлэвээс, хадан хавцал хэрэн нисэх бүргэд агаарт тогтож, гал дүрэлзсэн эрэмгий нүдээрээ ширтэж, аварга жигүүрийнх нь өд догшин салхинаа сөрвөлзөн байх мэт. Дамжуулах сүлжээний ажилтан гэдэг чухам энэ хүмүүс л юм даа

гэх бодол, бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрнө. Хариуцсан ажлаа дор бүрнээ чин сэтгэлээсээ гүйцэтгэхийн сацуу нэгэндээ болгоомжтой ажиллахыг зөвлөж, анхаарал тавьж, эв хамтын зүтгэл дор урагшилж байхыг харах уярам сайхан. Компанийн аваарын нөөцөөс зөөвөрлөгдөн ирж буй болон шинэ тулгууруудыг худалдан авах зэрэгт хүлээлт үүсэж цаг алдсаныг эс тооцвол 2 өдрийн дотор багтааж гэмтлийг устгах боломжтой гэдгийг тэдний шуурхай ажиллагаа харуулж байлаа.





“ЭРЧИМ ХҮЧНИЙ АЖИЛТНЫ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭВ

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн салбар нэгжүүд “Эрчим хүчний ажилтан”-ы өдрийг 2023.08.11-08.26-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлээ. Улаанбаатар салбарын хамт олон 2023 оны 08-р сарын 11-ний өдөр “Эрчим хүчний ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд тус арга хэмжээний үеэр эрхэлсэн ажилдаа амжилт гарган, олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны диспетчер

инженер Б.Даваасамбуу, ээлжийн инженер Д.Баярхүү, ээлжийн монтёр А.Хишигбаяр, Ц.Бадарч нарыг Эрчим хүчний яамны “Хүндэт жуух бичиг”-ээр, Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн техникч Д.Батбаярыг Монголын залуучуудын холбооны “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч” медалиар, Инженерийн албаны баланс тооцоо, хэмнэлтийн инженер А.Маралмаа, Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны диспетчер инженер

Ц.Миеэсүрэн нарыг Монголын залуучуудын холбооны “Хөдөлмөрийн алдар” медалиар, Засварын албаны дэд станцын засварын монтёр-гагнуурчин Н.Сумъяабазарыг Монголын залуучуудын холбооны “Тэргүүний залуу” алтан медалиар, 11 ажилтныг салбарын мөнгөн шагналаар, 6 ажилтныг Улаанбаатар салбарын Үйлдвэрчний эвлэлийн хорооны мөнгөн шагналаар тус тус шагнаж, баяр хүргэлээ. Арга хэмжээний хүрээнд үндэсний бөхийн

барилдаан зохион байгуулж, 32 бөх уран мэхийг уралдуулж, хүчийг үзэн барилдаж баярт ирсэн хамт олныхоо урмыг сэргээж, нүд сэтгэлийг баясгав. Хүчит бөхийн барилдаанд Засварын албаны шугамын засварын монтёр П.Санчирням түрүүлж, Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ээлжийн монтёр Ч.Буянтогтох үзүүлэлээ.



ЭХЯ-ны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдсан ажилтнууд салбарын удирдлагуудын хамт



МЗХ-ны шагналаар шагнагдсан ажилтнууд салбарын удирдлагуудын хамт



Салбарын мөнгөн шагналаар шагнагдсан ажилтнууд салбарын удирдлагуудын хамт



УБС-ын ҮЭХ-ны мөнгөн шагналаар шагнагдсан ажилтнууд салбарын удирдлагуудын хамт



Зүүн гар талаас: түрүүлсэн бөх П.Санчирням, үзүүлсэн бөх Ч.Буянтогтох

2023 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Төв удирдлагын ажилчид баяраа тэмдэглэсэн бөгөөд тус арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан хүчит

бөхийн барилдаанд Тээвэр механизмын хэлтсийн тусгай зориулалтын машин механизмын жолооч Ц.Оюунбилэг түрүүлж, гэрээт харуулын ажилтан Д.Самбуудорж

үзүүлсэн. Энэ үеэр олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтан, албан хаагчдад захирлын нэрэмжит шагнал гардуулж, баяр хүргэсэн юм. Мөн үеэр ЗӨБС-ын баяр

Багануур дүүрэгт зохион байгуулагдаж, Эрчим хүчний тэргүүний ажилтан -2, Эрчим хүчний яамны 100 жилийн медалиар 15 ахмад ажилтан шагнагдсан.



Төв удирдлагын өдөрлөгт түрүүлж үзүүлсэн бөхчүүд удирдлагуудын хамт



Салбарын 100 жилийн ойн медалиар шагнагдсан ахмад ажилтнууд



ЭХ-ний тэргүүний ажилтнаар ЗА-ны засварын монтёр А.Төрхишиг



ЭХ-ний тэргүүний ажилтнаар ЗА-ны дарга Г.Болдхуяг

Хангайн бүсийн салбар 2023 оны 08 дугаар сарын 26-ны өдөр “Эрчим хүчний ажилтан”-ы өдрөө тэмдэглэж, ажил үйлсээрээ манлайлсан ажилчиддаа шагнал гардуулсан юм. “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар Салбарын ерөнхий инженер

Б.Анхбаяр, “Эрчим хүчний тэргүүний ажилтан” цол тэмдгээр Хархорин хэсгийн нярав Б.Отгонцэцэг, ЗАА-н албаны сургалт, бүтээмжийн инженер Б.Ундрах Орхон аймгийн ҮЭХ-ны “Хүндэт тэмдэг”-ээр АШҮ-ний албаны дарга А.Гомбосүрэн, СЭЗ-ийн

албаны нягтлан бодогч М.Золжаргал, ЗАА-н албаны тогооч Ж.Ариунжаргал, Орхон аймгийн ҮЭХ-ны “Хүндэт жуух бичиг”-ээр Засварын албаны техникч Г.Нандинцэцэг, ЗАА-н албаны туслах тогооч - бэлтгэгч Т.Мөнх-Өлзий, үйлчлэгч Ц.Хүрэлсүх нар

шагнуулсныг гардууллаа.


Баярын үеэр нийт ажилтнуудын дунд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, шагайн харваа болон дэмбээ хурууны тэмцээн зохион байгуулагдсан.



Талархал

“ЦДҮС” ТӨХК-ийн Зүүн-Өмнөд бүсийн салбарын зураг, төсвийн инженер А.Эрдэнэтогтохын элэг шилжүүлэн суулгах хагалгаанд чин сэтгэлийн тусалцаа үзүүлсэн Улаанбаатар салбар, Төвийн бүсийн салбар, Хангайн бүсийн салбар, Говийн бүсийн салбар, Зүүн-Өмнөд бүсийн салбарын болон компанийн удирдлага нийт хамт олон та бүхэндээ баярлаж талархсанаа илэрхийлж байна. Та бүхний минь ажил үйлс амжилт бүтээлээр дүүрэн, эрүүл саруул байхын ерөөл өргөө.

Хүндэтгэсэн: А.Эрдэнэтогтохын гэр бүлээс



“НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ”

БУЛАН

ТАЙЛБАР: Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай цувралаар нийтэлж байна.

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАРЫН ОН ДАРААЛЛЫН ТОВЧООН (ЦУВРАЛ-3)

Улсын ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 3 жилийн, IV V жилийн (1965-1970 он) төлөвлөгөөгөөр уулын олборлох үйлдвэр зэрэг аж үйлдвэрийн салбарыг шинээр хөгжүүлэх зорилтын хүрээнд Монгол Зөвлөлтийн хамтарсан Уулын баяжуулах Эрдэнэт комбинатыг нийгэм ахуйн цогцолборын хамт цахилгаан дулаанаар хангахын тулд Улсын хил-Дархан-Эрдэнэтийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, цагт 75 тонн уур гаргах хүчин чадал бүхий 6 зуухтай дулааны станцыг барьжээ.

БНМАУ, ЗХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Булган аймгийн нутагт орших “Эрдэнэтийн овоо” ордыг түшиглэсэн Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн цахилгаан ачаалал нь 100 мвт хүрэх тооцоотой тул улс хоорондын ЦДАШ-ууд д/с-ууд барихаар төлөвлөн Цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 220 кВ-ын хос хэлхээт “Селендум-Дархан” шинэ шугам барьж Дархан 220/110/35-кВ-ын ашиглалтад орсноор 1973 оны 5-р сард Эрдэнэт хотын болон төвийн бүсийн баруун аймгуудын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах гол шугам болох “Дархан-Эрдэнэт”-ийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын анхны тулгуурыг Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг, “Зараагийн хөндий” гэдэг газарт Зөвлөлт-Монголын эрчим хүчний барилгачид босгожээ.

Сэлэнгэ аймгийн Орхон сумын 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаас салбарлуулан 110кВ-ын хүчдэлээр 2х6300кВА-ын түр дэд станцаас Эрдэнэт хотыг 1974 оны өвлөөс тэжээх болжээ.

Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газрын даргын 1974 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 164 тоот тушаалд 1974 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн материал хангамжийн инженер Б.Балжирыг Эрдэнэтийн дэд станцын инженерээр томилж ажиллуулсан байдаг. Мөн түр дэд станцын анхны мастераар Т.Чулуунбаатар, монтёроор Ц.Батсуурь, С.Төрөө нар томилогдож байсан бол 1976 онд “Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газар”-ын харьяа Эрдэнэтийн салбар байгуулагдаж салбарын даргаар Б.Батнасан томилогджээ.

1975 онд 110кВ-ын Эрдэнэт-Хялганатын 2 хэлхээт шугам, 110/10кВ-ын 2х2500кВА дэд станцууд, насосны станцын салбар шугам, дэд станц ашиглалтад оров. Эрдэнэт-Улаантолгой 35кВ-ын шугам, дэд станцууд ашиглалтад орсон. 1977 оны 12-р сард Дарханы 220кВ-ын дэд станц, Дархан-Эрдэнэтийн 155кВ, 220кВ-ын хоёр хэлхээт/201,202/ шугам ашиглалтад орсноор Эрдэнэтийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж өндөр хүчдэлийн шугам дэд станцууд ихээр баригдсан тул Дархан-Сэлэнгийн ЦШС-ний харьяа Эрдэнэтийн ЦШС-ний салбар байгуулж, энэ байгууллагын анхны суурь нь тавигдсан юм. Эрдэнэтийн салбарын инженер техникийн ажилтан, албан хаагч, ажилчид, нийт 56 хүний бүрэлдэхүүнтэй, тус салбарын даргаар Дашбатын Баттогтох ажиллаж байсан.

1979 оны намар 110 кВ-ын Эрдэнэт-Булганы 58 км 2 хэлхээт шугам, 35 кВ-ын хүчдэлтэй 35/6 кВ-ын түр дэд станц барьж Булган аймгийн төв ТЭХ-ний нэгдсэн системд холбогдсон ЦШС-ний салбар байгуулагдаж салбарын даргаар Д.Бадарч томлигдсон байна.

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1980 оны 12-р сарын 5-ны өдрийн 377-р тогтоолоор түлш эрчим хүчний яам харьяа төвийн эрчим хүчний системийн Эрдэнэт-Булганы цахилгаан шугам сүлжээний газар байгуулагджээ.

Эрдэнэт-Булганы ЦШС-ний газарт бүтцийн өөрчлөлт хийж, үйлдвэр техникийн хэлтэс диспетчерийн алба, эрчим хүч борлуулах алба, Булган хот дахь салбар, шугамын хэсэг, дэд станцын хэсэг, авто граж, захиргаа, аж ахуй, санхүү зэрэг үйлдвэрлэлийн найман нэгжтэй 120 гаруй ажиллагсадтайгаар өөрийн үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Энэ бүтцийн өөрчлөлттэй холбогдуулж тус газрын анхны дарга Ц.Баасандорж, үйлдвэр техникийн хэлтсийн даргаар Д.Баттогтох, Дэд станцын ахлах мастераар Д.Амгаланбаатар, Шугамын ахлах мастераар Л.Нацагдорж, Байцаагч инженерээр О.Чагнаадорж, Булганы салбарын даргаар Д.Бадарч, дэд станцын хэсгийн реле хамгаалалтын инженерээр Г.Пүрэвдорж, Мөн реле хамгаалалт хэмжүүрийн инженерээр Н.Батмөнх, туршилтын мастераар Б.Лхагвасүрэн, диспетчерийн албаны теле механик, өндөр үелзлэлийн холбооны инженерээр Г.Хаянхярваа, Диспетчерийн албаны ээлжийн диспетчер инженерээр Ц.Дашням, Н.Жамъянмядаг, Б.Балжир, А.Сономцэрэн нар ажиллаж байв.

Булган-Хархорины 200 гаруй км 110 кВ-ын 2 хэлхээ шугам

2х10000 кВА-ийн чадалтай 110/35/10 кВ-ын дэд станцыг Монгол Улсын эрчим хүчний барилга угсралтын байгууллагын хүчээр ашиглалтад оруулснаар Булган, Архангай, Өвөрхангай аймгуудын төв тэдгээрийн сумд төвлөрсөн эрчим хүчний системд холбогдох нөхцөл бүрдсэн.

Хархорин суманд ЦШС-ний салбар байгуулагдаж салбарын даргаар Ц.Дашдорж томлигдсон байна.

1986-1987 онд Гурванбулаг, Сансарын 50км 110кВ-ын шугам, 110/35/10кВ-ын дэд станц Хишиг-Өндөрийн 110кВ-ын салбар шугам 110/35/10кВ-ын дэд станцууд ашиглалтад орсноор, Рашаант, Эрдэнэсант, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Орхон, Могод сумд руу 35кВ-ын шугам баригдав. Мөн Хархорины дэд станцаас Хужирт, Хотонт, Хашаат сумдад 35кВ-ын шугамууд баригдаж Булган, Хархоринд өөрийн харьяа салбаруудыг зохион байгуулж, өндөр, нам хүчдэлийн шугамын ашиглалт засварыг хариуцуулжээ.

1988 онд Улаанбаатар-Эрдэнэтийн 2 хэлхээт 220кВ-ын 300 орчим км урт шугам /203,204/ ашиглалтад орсноор Эрдэнэт хот болон төвийн бүсийн баруун, баруун хойд зүгийн аймгуудын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж үйлчилгээний хүрээ өргөсөн бүтэц зохион байгуулалтын хувьд сайжирсан.

Эрчим хүч, Уул уурхайн үйлдвэр, Геологийн яамны зарим байгууллагыг өөрчлөн байгуулах тухай” БНМАУ-ын СНЗ-ийн /хуучин нэрээр/ 292-р тогтоолоор Дархан-Сэлэнгийн ЦШС-ний газар, Эрдэнэт-Булганы ЦШС-ний газрыг нэгтгэн Дархан-Эрдэнэтийн ЦШС-ний газар болон өөрчлөгдсөн.

1987 ЭБЦШС-ний газрын даргаар Я.Базаррагчаа, ерөнхий инженер Д.Ядамбаатар нар томилогдсон бол 1990 онд Д.Түвшинтөгс удирдсан.

1988-1989 онуудад Хархорин-Цэцэрлэгийн 110 кВ-ын шугам 1 х 6300 кВА чадалтай 110/6 кВ-ын түр дэд станцын хамт ашиглалтад орсноор Архангай аймгийн төв эрчим хүчний нэгдсэн системд холбогдов.

Архангай аймгийн 110 кВ-ын түр дэд станц аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрт харьяалагдаж даргаар нь Г.Эрхэм, ерөнхий инженерээр Д.Гомбосүрэн ажиллаж байжээ.

1990 онд цэцэрлэгийн 2 х 10000 кВА чадалтай 110/35/10 кВ-ын хүчдэлтэй дэд станц ашиглалтад орж түр дэд станцыг хүчдлээс чөлөөлөв.

1990 онд Хархорин-Арвайхээрийн 110кВ-ын шугам, 110/35/10кВ-ын дэд станц ашиглалтад оров.

ЭБЦШС-ний 1991-1993 ерөнхий инженерээр 1993-1997 газрын даргаар Д.Жанчив, 1997 оноос Г.Пүрэвдорж нар ажиллаж байв.

1993 онд 110 кВ-ын шугам дэд станцууд ЦШС-ний газруудын ашиглалтад шилжих болсон тул Цэцэрлэгийн 110/35/10 кВ-ын дэд станцын мастераар Б.Дорждамба томилогдож Хархорины ЦШС-ний салбарын харьяанд ажиллах болсон.

1998 оны 11-р сард Эрдэнэтийн ЦШС-ний газрын үйлдвэрлэлийн шинэ бааз ашиглалтад орсон.

2001 оны 2-р сарын 1-ний өдөр эрчим хүчний тухай хууль батлагдаж эрчим хүчний үйлдвэрүүд арилжааны хэлбэрт шилжих болов.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийг байгуулжээ.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2001 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэр, ТБЦДС ТӨХК-ийн захирлын 2001 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тушаалаар Эрдэнэт-Хархорины салбарыг байгуулсан. Энэхүү тушаалаар салбарын даргаар Д.Жанчив, Ерөнхий инженерээр Г.Хаянхярваа, ахлах нягтлан бодогчоор В.Хандмаа нар томилогджээ.

Үйлдвэрлэлийн нэгжүүдээ цехгүй буюу хэсгүүдээр зохион байгуулжээ. Үүнд:

Булганы хэсгийн ахлах инженерээр Б.Батцогоог, Архангайн хэсгийн ахлах инженерээр Ч.Хүрэлбаатарыг, Өвөрхангайн хэсгийн ахлах инженерээр Б.Жаргалыг, Хархорины хэсгийн ахлах инженерээр Б.Чүлтэмийг, Ахлах диспетчерээр Т.Ганбаатарыг, Ашиглалт засварын ахлах инженерээр Ц.Амгаланбаатар, Авто аж ахуйн хэсгийн даргаар О.Ганбаатар нар тус тус томилогджээ.

Эрдэнэт-Хархорины салбарын эхлэлтийн балансаар 2666.2 сая төгрөгийн дүрмийн сантай 3086.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 76.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2001 оны 07 дугаар сарын 01-ний байдлаар 220кВ-ын

шугам 210км, 110кВ-ын 2 хэлхээт шугам 387.7км , 110кВ-ын нэг хэлхээт шугам 242.5 км, 35кВ-ын 2 хэлхээт шугам 2.6 км, 35кВ-ын 1 хэлхээт шугам 2.7, 220/110/35/6кВ-ын 2 х 125000 кВА чадалтай автотрансформатор, 110/35/6кВ-ын 2 х 40000 кВА чадалтай трансформатортай дэд станц 1, 110/35/10кВ-ын 2 х 10000 кВА чадалтай трансформатортай дэд станц 4, 110/10кВ-ын хүчдэлтэй 2 х 2500 кВА –гийн чадалтай трансформатортай дэд станц 1, 110/35/10кВ-ын 1х 6300 кВА чадалтай дэд станц 2-той байжээ.

2002 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ЭБЦДС ХК-ийн конторт хамт байрлаж байсан байна.

2003 оны 7 дугаар сарын 23-нд улсын хөрөнгө оруулалтаар Булган-Мөрөнгийн 110кВ-ын ЦДАШ-ын шав тавих ёслол болж, УИХ-ын дарга С.Төмөр-Очир , ерөнхий сайд Н.Энхбаяр, дэд бүтцийн сайд Б.Жигжид нар оролцов.

2004 оны 08 дугаар сарын 09-нд 110кВ-ын Булган-Мөрөнгийн 292 км урт ЦДАШ, 110/35/10кВ-ын хүчдэлтэй 6300 кВА чадалтай дэд станцын хамт ашиглалтад орж ахлах инженерээр Д.Отгонбаяр томилогдов.

2005 онд 110кВ-ын Арвайхээр-Баянтээг-Баянхонгорын 205.5км ЦДАШ, 110/35/10кВ-ын Баянтээг, 110/35/6кВ-ын Баянхонгор дэд станцууд ашиглалтад орж ахлах диспетчерээр Б.Баттулга томилогдов.

110кВ-ын Арвайхээр- Баянхонгор ЦДАШ-ын 2005 оны 05 дугаар сарын 13-ны 23 цагт хүчдэл өгч залгасан. (салбарын диспетчер Ц.Жаргалмаа шийдвэрээр) 110/35/6кВ-ын Баянхонгор дэд станц 2005 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 00 цаг 50 минутад хүчдэл өгч, 02 цаг 30 минутад ачаалал авахуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 108 дугаар тогтоол, хувь нийлүүлэгчдийн хурлын 2012 оны 05, 07 дугаар тогтоол, “компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай” төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 20 дугаар тогтоолоор компанийн болон салбарын нэр, бүтэц , орон тоо өөрчлөгдөж манай салбар 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн Хангайн бүсийн салбар нэртэйгээр 5 алба, 1 хэсгийн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж эхэллээ.

Компанийн гүйцэтгэх захирлын 2012 оны 6/104,109 дүгээр тушаалаар салбарын даргаар Ц.Амгаланбаатар, ерөнхий инженерээр Б.Эрдэнэцогт, Эдийн засаг, санхүүгийн албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогчоор В.Хандмаа, ХАБЭА, дотоод хяналтын инженерээр Ё.Ариунаа, Захиргаа аж ахуйн албаны даргаар Д.Эрдэнэчимэг, Ашиглалтын албаны даргаар Д.Золзаяа, РХХТ-ын албаны даргаар Б.Анхбаяр, Засварын албаны даргаар А.Гомбосүрэн, Хархорины хэсгийн даргаар Б.Чүлтэм нарыг томилж байсан.

Улсын хөрөнгө оруулалтаар 125 МВА автотрансформаторыг 200 МВА автотрансформатораар солих ажлыг “Цагаан хорол” ХХК БНХАУ-ын үйлдвэрлэсэн автотрансформатор солих ажил гүйцэтгэсэн.

Ат-1 трансформаторыг 2013 оны 05 сарын 22-ны 06 цаг 38 минутад залгаж хүчдэл дор 10 цаг 31 минутад ачаалал дор залгасан. 200 МВА ат-2 тр-ыг 2013 оны 06 дугаар сарын 18-ны өдөр 19 цаг 02 минутад залгаж хүчдэл дор 21 цаг 31 минутад ачаалал дор залгасан.

Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ДЦС-ын 45 мВт өргөтгөлийн ажлын хөрөнгөөр барьсан 110 кВ-ын 2 хэлхээ эт-151-р ЦДАШ-г 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 18 цаг 27 минутад залгасан. ЭТ-152-р ЦДАШ-ыг 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 15 цаг 03 минутад залгасан.

Улсын Их Хурлын эдийн засгийн байнгын хорооны 2015 оны 02-р тогтоол, засгийн газрын 2015 оны 211, 464 –р тогтоол, шийдвэрийн дагуу “ЭДЦС” ТӨХК-ийн хүчин чадлыг 50 мВт-ын турбогенератороор өргөтгөх, зарим тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн ажлыг гүйцэтгүүлэхээр 2021 оны 08 сарын 09 техникийн комиссын шийдвэрээр диспетчер Б.Уртсанаа 17 цаг 58 минутад хүчдэл өгсөн 110 кВ-ын 1 хэлхээ ЭТ-153-р ЦДАШ-н Эрдэнэт дэд станцтай холбогдож ашиглалтад оров.

Эрхлэн гаргасан: Захиргаа удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Д.Энхбаяр